

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	7
2.8.1. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	7
2.8.2. Авлага	9
2.8.3. Урьдчилгаа	10
2.8.4. Бараа материал, Бусад эргэлтийн хөрөнгө	10
2.8.5. Үндсэн хөрөнгө	11
2.8.6. Өр төлбөр	12
2.8.7. Засгийн газрын хувь оролцоо	12
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	13
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	14
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	15
2.12. Шилэн дансны мэдээлэл	15
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	15
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	16
3. Менежментийн захидал	17
3.1. Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал.....	17
3.2. Зардалтай холбоотой асуудал	17
3.3. Дотоод аудиттай холбоотой асуудал	18
3.4. Орон тоотой холбоотой асуудал	18
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.1. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	20
4.2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	21
4.3. Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	22
4.4. Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	24
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	25
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26
5.1. Зөрчлийн нэгтгэл.....	27
5.2. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл	29
5.3. Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн төлбөрийн албан шаардлагын нэгтгэл	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
С.ЧИНЗОРИГ ТАНАА

2020.04.04 № 1438
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Нийгмийн даатгалын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


- Монгол банкнаас хянасан зохист харьцааны үзүүлэлт шаардлага хангахгүй, санхүүгийн байдлын тайлангаар алдагдалтай, өөрийн хөрөнгийн хэмжээ болон эрсдэлийн сан сөрөг дүнтэй байгаа нэр бүхий 2 банкны харилцах дансанд байршиж байгаа 100,943.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн;
- Залруулагдаагүй 121,961.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 23,989.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа

зэрэг нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Сангийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн батлагдсан орон тооны хязгаарт багтааж ажиллах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн цогц программын шинэчлэлт хөгжүүлэлтийг хийх, дотоод аудитын үр нөлөөг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 05-наас 2020 оны 04 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Б.Долгоржав гүйцэтгэв.

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/627 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нийгмийн даатгалын сан нь “даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх” гэсэн эрхэм зорилготойгоор 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болохоор хэтийн зорилгыг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;
- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;
- Улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- Доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар цэргийн алба хаасны бүрэн тэтгэврийн доод хэмжээг 310.0 мянга, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 270.0 мянган төгрөгт хүргэх, ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчилсөн
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Жишиг норм”
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд 2006 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг, 2007 оноос “Санхүү” нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг ашиглан санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэсэн байна. Тайлант онд нийгмийн даатгалын сан, үйл ажиллагааны санхүүгийн цогц программыг

нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хамт шинэчлэн боловсруулж байгаа ч эцэслэгдээгүй байна.

Нийгмийн даатгалын сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Нийгмийн даатгалын сангийн Дотоод аудит, мониторингийн газар өөрийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгээгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Нийгмийн даатгалын сангийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 чиглэлд 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын түвшний суурь үзүүлэлтээс 1.0 хувиар тооцсон нь эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны эхний хагас жилийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,179,462.0 сая төгрөгийн 1 хувь буюу 11,794.6 сая төгрөгөөр тогтоож баталгаажуулав.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 23,989.4 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн суурь үзүүлэлт 2,398,936.7 сая төгрөгөөс тооцсонтой холбоотой болно.

2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 948,531.4 сая, эцсийн үлдэгдэл 1,262,586.2 сая төгрөг болж, 314,054.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	509,196.4	778,306.2	269,109.8
Төрийн сангийн харилцах	84,051.9	62,768.8	-21,283.1
Нэмэлт санхүүжилтийн харилцах	2.2	22.3	20.1
Арилжааны банкны харилцах	425,142.3	715,515.1	290,372.8
Хадгаламж	439,335.0	484,280.0	44,945.0
Дүн	948,531.4	1,262,586.2	314,054.8
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	0.0	0.0	0.0

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсөл/ сан	948,531.4	1,262,586.2	313,054.8
Дүн	948,531.4	1,262,586.2	314,054.8

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдлээс Төрийн сангийн харилцах дансанд 5.0 хувь буюу 62,791.1 сая төгрөг, арилжааны банкны харилцах дансанд 95.0 хувь буюу 1,199,795.1 сая төгрөг байна.

Арилжааны банканд дахь мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 864,477.3 сая төгрөг байснаас 335,317.8 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 1,199,795.1 сая төгрөг болсон нь даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, банкны хүүгийн орлого нэмэгдсэнтэй холбоотой байна. Банканд байршиж буй мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдлээс төв, нийслэлийн байгууллагуудын төгрөгийн харилцах дансанд 1,162,523.2 сая, орон нутгийн байгууллагуудын төгрөгийн харилцах дансанд 65,284.5 сая, гадаад валютаар БНСУ-ын арилжааны 4 банкны харилцах дансанд 34,778.5 сая төгрөг тус тус байна.

Арилжааны банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлүүдийн хадгаламж хэлбэрээр байршуулсан мөнгөн хөрөнгө өмнөх оноос 44,945.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №2. Арилжааны банкнуудад байршуулсан хадгаламж

Үзүүлэлт	/сая төгрөг/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
Улаанбаатар хотын банк	68,355.0	33,900.0	-34,455.0	7.0
Голомт банк	100,580.0	2,550.0	-98,030.0	0.5
Капитал банк	2,400.0	-	-2,400.0	-
Капитрон банк	16,900.0	12,020.0	-4,880.0	2.5
Төрийн банк	50,000.0	128,000.0	78,000.0	26.5
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	31,830.0	5,030.0	-26,800.0	1.0
Хаан банк	54,000.0	170,000.0	116,000.0	35.1
Чингис хаан банк	70,120.0	57,180.0	-12,940.0	11.8
Кредит банк	-	29,000.0	29,000.0	6.0
Тээвэр хөгжлийн банк	45,000.0	45,000.0	-	9.3
Худалдаа хөгжлийн банк	150.0	1,600.0	1,450.0	0.3
Дүн	439,335.0	484,280.0	44,945.0	100

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

НДС-ийн чөлөөт үлдэгдлийн хадгаламжийн 484,280.0 сая төгрөгөөс 2.2 хувь буюу 10,500.0 сая төгрөг тэтгэмжийн, 95.5 хувь буюу 462,810.0 сая төгрөг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний, 2.3 хувь буюу 10,970.0 сая төгрөг ажилгүйдлийн даатгалын хадгаламжууд эзэлж байна.

2019 онд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлүүдийг хадгаламж хэлбэрээр Кредит банканд шинээр байршуулж, татан буугдсан Капитал банканд байршиж байсан 104,206.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн данснаас авлагад шилжүүлэн бүртгэсэн байна.

Хүснэгт №3. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, даатгалын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
Тэтгэврийн даатгал	149,128.9	381,121.2	231,992.3	30.2
Тэтгэмжийн даатгал	32,795.9	61,025.1	28,229.2	4.8
ҮОМШӨвчний даатгал	608,576.8	707,808.6	99,231.8	56.1
Ажилгүйдлийн даатгал	142,019.9	101,471.1	-40,548.8	8.0
Эрүүл мэндийн даатгал	11,267.0	7,776.3	-3,490.7	0.6
Төвлөрсөн харилцахын хөрөнгө	4,163.7	2,807.7	-1,356.0	0.2
Үйл ажиллагаа	579.2	576.2	-3.0	0.1
Дүн	948,531.4	1,262,586.2	314,054.8	100

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Нэр бүхий 2 банкны хэвийн үйл ажиллагаа Монголбанкнаас тавигдах зохист харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахгүй байгаагаас 62,210.0 сая хадгаламж, 38,733.8 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэл нийт 100,943.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө эрсдэлтэй;
- Тайлант онд харьяа газар, хэлтсүүд “Ахмадын сан”-гийн данс нээж төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэл 212.8 сая төгрөгийн үлдэгдлийг байршуулсан;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 94.8 сая төгрөгийн ажил гүйлгээг зөвшөөрч ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Нийслэлийн НДГ 3.5 сая, ХУД-ийн НДХ 38.5 сая, БХД-ийн НДХ 14.2 сая, Булган аймгийн НДХ 2.9 сая, Өмнөговь аймгийн НДХ 3.4 сая, Сэлэнгэ аймгийн НДХ 15.2 сая, Дорнод аймгийн НДХ 18.9 сая төгрөг/;
- Томилолтоор ажилласан албан тушаалтанд хоол унааны мөнгийг давхардуулж нийт 0.2 сая төгрөг олгосон. /Говьсүмбэр аймгийн НДХ 0.1 сая, Орхон аймгийн НДХ 0.1 сая төгрөг/;
- Хэнтий аймгийн НДХ иргэдэд үйлчилсэн архивын лавлагааны орлогыг арилжааны банканд данс нээж, төвлөрүүлсэн;
- Булган аймгийн НДХ шүүхийн шийдвэрийн дагуу ажилдаа буцан орсон 5 албан хаагчийн ажилгүй байх хугацааны нийт 35.4 сая төгрөгийн цалинг байгууллагаас нөхөн төлж хохирлыг барагдуулсан.

2.8.2. Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 126,488.8 сая, эцсийн үлдэгдэл 251,411.3 сая төгрөг болж, 124,922.5 сая

Хүснэгт №4. Авлагын дансны үлдэгдэл, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	117,011.6	138,273.0	21,261.4
Татаас, санхүүжилтийн авлага	5.1	0.0	-5.1
Байгууллагаас авах авлага	9,455.8	113,072.0	103,616.2
Хувь хүмүүсээс авах авлага	16.3	66.3	50.0
Дүн	126,488.8	251,411.3	124,922.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага			
Төсөл/ сан	126,488.8	251,411.3	124,922.5
Дүн	126,488.8	251,411.3	124,922.5

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 55.0 хувийг төлбөртэй үйлчилгээний, 45.0 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна.

Тайлант онд төлбөртэй үйлчилгээний авлага харилцагчийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлтийн улмаас 21,261.4 сая төгрөгөөр, хувь хүмүүсээс авах авлага нь БНСУ-ын НД албаны ажилчдын байрны барьцааны авлага 50.0 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага нь татан буугдсан Капитал банканд байршиж байсан мөнгөн хөрөнгөөс шилжүүлсэн бүртгэсэн 103,616.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын 1,111.4 сая төгрөгийн үлдэгдлийн тооцоог нийлж баталгаажуулаагүй /Сэлэнгэ аймгийн нэгжүүд 30.4 сая, Булган аймгийн НДХ 350.4 сая, БГД-ийн НДХ 23.9 сая, СБД-ийн НДХ 685.7 сая, Баянхонгор аймгийн НДХ 6.9 сая, Дорноговь аймгийн НДХ 21.0 сая/;
- Авлагыг 1,962.9 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, бүртгээгүй. /СБД-ийн НДХ 120.7 сая, СБД-ийн НДХ 479.6 сая, Булган аймгийн НДХ 0.9 сая, Дорноговь аймгийн НДХ 1,167.8 сая, Төв аймгийн НДХ 185.6 сая/;
- Олон жил болсон 4,021.9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй /НДЕГ 20.9 сая, Дорнод аймгийн НДХ 399.3 сая, Баянхонгор аймгийн НДХ 4.0 сая, Говьсүмбэр аймгийн НДХ 3,558.0 сая, Ховд аймгийн 39.7 сая/.

2.8.3. Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 0.9 сая, эцсийн үлдэгдэл 1.2 сая төгрөг болж, 0.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №5 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

үлдэгдэл /сая төгрөг/ Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.4	0.4	0.0
Цалингийн урьдчилгаа	0.5	0.8	0.0
Дүн	0.9	1.2	0.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага			
Төсөл/ сан	0.9	1.2	0.3
Дүн	0.9	1.2	0.3

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны урьдчилгаа 0.4 сая төгрөг нь ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтантай холбоотойгоор үүссэн, тайлант онд үүссэн 0.8 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа төлбөр байна.

2.8.4. Бараа материал, Бусад эргэлтийн хөрөнгө

Бараа материалын эхний үлдэгдэл 1,073.9 сая, эцсийн үлдэгдэл 952.4 сая төгрөг болж, 121.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Бараа материалын данс, байгууллагын төрлөөр /сая төгрөг/ үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бэлэн бүтээгдэхүүн	101.9	101.9	0.0
Хангамжийн материал	972.0	850.5	-121.5
Бичиг хэргийн материал	24.2	32.3	8.1
Аж ахуйн материал	331.0	298.4	-32.6
Сэлбэг хэрлэгсэл	11.4	37.9	26.5
Түлш, шатах тослох материал	0.9	0.7	-0.2
Бусад хангамжийн материал	604.5	481.2	-123.3
Бусад эргэлтийн хөрөнгө	150.9	21.6	129.3
Дүн	1,224.8	974.0	250.8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага			
Төсөл/ сан	1,224.8	974.0	250.8
Дүн	1,224.8	974.0	250.8

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал худалдан авсан 977.4 сая, хандиваар 3.5 сая, шилжүүлэн авсан 611.9 сая нийт 1,592.9 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 1,093.0 сая, шилжүүлсэн 621.4 сая нийт 1,714.4 сая төгрөгөөр буурсан байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 150.9 сая төгрөг нь Өвөрхангай аймгийн НДХ-ийн барилга ашиглалтад орсноос үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн дүнгээр буурч, 21.6 сая төгрөгийн үлдэгдэл нь дуусаагүй барилга данснаас шилжүүлсэн Баянзүрх дүүргийн НДХ-ийн барилгын зураг төсөл бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авсан 8.1 сая төгрөгийн бараа, аж ахуйн материалыг зардалд шууд бүртгэсэн. /БХД-ийн НДХ 0.1 сая, Булган аймгийн НДХ 0.1 сая, Баянхонгор аймгийн НДХ 7.9 сая/;
- Сэлэнгэ аймгийн НДХ 558.2 мянган төгрөгийн бараа материалын орлого, зарлагын ажил гүйлгээ гарсан тухай бүрд бүртгэлгүй, бөөн дүнгээр нэгтгэн бүртгэсэн.

2.8.5. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 37,146.1 сая, эцсийн үлдэгдэл 35,598.9 сая төгрөг болж, 1,547.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7 Үндсэн хөрөнгийн данс, байгууллагын төрлөөр /сая төгрөг/ үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	29,898.8	29,266.1	-632.7
Тээврийн хэрэгсэл	750.5	426.5	-324.0
Машин, тоног төхөөрөмж	3,046.3	2,747.6	-298.7
Тавилга, эд хогшил	1,903.5	1,631.7	-271.8
Дуусаагүй барилга	21.6	-	-21.6
Бусад үндсэн хөрөнгө	2.6	2.3	-0.3
Программ хангамж	433.5	341.6	-91.9
Бусад биет бус хөрөнгө	1,089.3	1,183.1	93.8
Дүн	37,146.1	35,598.9	-1,547.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага			
Төсөл/ сан	37,146.1	35,598.9	-1,547.2
Дүн	37,146.1	35,598.9	-1,547.2

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгөөс барилга, байгууламж 82.2 хувь, тоног төхөөрөмж 7.7 хувь, тавилга, эд хогшил 4.6 хувь, бусад биет бус хөрөнгө 3.3 хувь, тээврийн хэрэгсэл 1.2 хувь, программ хангамж 1.0 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 7.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 15,902.6 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 140.1 сая нийт 16,050.6 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 14,860.8 сая, акталсан 730.9 сая нийт 15,591.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөөс 1,089.3 сая төгрөгийн хөрөнгө нь газар байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан 140.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд Сүхбаатар дүүргийн ЗДТГ-аас шилжүүлсэн 49.0 сая төгрөгийн барилга, ХНХЯ-аас шилжүүлсэн 8.7 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, Баянзүрх дүүргийн ЗДТГ-аас шилжүүлсэн 54.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн, Баянзүрх дүүргийн ЗДТГ, ХНХЯ-аас шилжүүлсэн 28.4 сая төгрөгийн тавилга эд хогшил байна.

Балансаас баланст шилжүүлж авсан 15,902.6 сая болон шилжүүлсэн 14,860.8 сая төгрөгийн хөрөнгө нь Сангийн яамны Төрийн сангийн и-тайланд Нийслэлийн НДГ-ын нэгтгэлийн дүнг 9 дүүргээр салгаж бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд 1594 ширхэг 730.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2019 оны 593, А-1/4240 тоот шийдвэрээр акталсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Булган аймгийн НДХ техник эдийн засгийн үндэслэлгүй, зураг төсөв байхгүй барилгын дулааны узель хийх ажлыг "Их-Азар" ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч уг ажлыг гүйцэтгэх байршил тодорхойгүйгээс одоог хүртэл ажил хийгдээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцоогүй;
- Завхан аймгийн НДХ засварын зардлаас байгууллагын гаднах хайс хамгаалалтын ажилд гэрээний хугацаанд ажил гүйцэтгээгүй байхад 2.0 сая төгрөгийг олгосон;
- Дарааллын дугаар олгогч машиныг Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн НДХ-үүд 11.9 сая төгрөгөөр 2016 онд худалдан авсан боловч одоог хүртэл ашиглалтгүй;
- Төв аймгийн НДХ элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 65 нэр төрлийн хөрөнгүүдийг дахин үнэлж тайланд тусгаагүй, Баянзүрх дүүргийн НДХ 10.0 сая, Говьсүмбэр аймгийн НДХ 15.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө бүртгэлтэй.

- *Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны санхүүгийн программ хангамжийг 2006 оноос ашиглаж байгаа ба зарим журнал, дэлгэрэнгүй бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн харьцуулсан мэдээллүүд боловсруулагдаагүй, санхүүгийн тайлангийн программаас аудитын шаардлагатай загварын дагуу мэдээллүүд хөрвүүлэгддэггүй нь Сангийн Сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн програмд тавигдах шаардлагыг хангахгүй байгааг НДСан, НДЕГ, Дорнод, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгийн НДХ-ийн санхүүгийн аудитын тайланд дурдагдсан байна.*

2.8.6. Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 22,701.4 сая, эцсийн үлдэгдэл 21,007.9 сая төгрөг болж, 1,693.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8 Нийт өр төлбөрийн данс, байгууллагын төрлөөр /сая төгрөг/ үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Өглөг	2,534.0	5,088.4	2,554.4
Ажилчидтай холбоотой өглөг	525.7	66.5	-459.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,007.7	5,021.1	3,013.4
Татаас санхүүжилтийн өглөг	0.0	0.2	0.2
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	0.6	0.6	0.0
Бусад өглөг	11,281.8	7,792.5	-3,489.3
Байгууллагад төлөх өглөг	11,281.8	7,792.5	-3,489.3
Урьдчилж орсон орлого	8,885.6	8,127.0	-758.6
Дүн	22,701.4	21,007.9	-1,693.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
<i>Төсөвт байгууллага</i>			
Төсөл, сан	22,701.4	21,007.9	-1,693.5
Дүн	22,701.4	21,007.9	-1,693.5

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өглөгийн 60.5 хувийг байгууллагад өгөх, 39.0 хувийг бараа үйлчилгээний зардлын, 0.5 хувийг ажилчидтай холбоотой өглөг эзэлж байна.

Тайлант онд бараа үйлчилгээний зардлын өглөг 3,013.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь даатгуулагчдад олгохоор тооцсон тэтгэвэр, тэтгэмжийн үлдэгдэл, байгууллагад төлөх өглөгийн үлдэгдэл 7,792.5 сая төгрөг нь ЭМДС-ийн харилцах дансны үлдэгдэл байна.

Урьдчилж орсон орлого нь ажил олгогч, даатгуулагчдын шимтгэлийн илүү төлөлтийн мөнгө бөгөөд өмнөх жилүүдийн төлөлт барагдаж, тайлант хугацааны төлөлтөөс үүссэн орлого юм.

Татаас санхүүжилтийн өглөг нэмэлт санхүүжилттэй холбоотойгоор 0.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг нь Булган аймгийн НДХ-т өмнөх онд үүссэн өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

- *Тайлант онд 19.8 сая төгрөгийн өр үүсгэсэн /Нийслэлийн НДГ 0.9 сая, Хан-Уул дүүргийн НДХ 2.7 сая, Сэлэнгэ аймгийн НДХ 14.4 сая, Баянхонгор аймгийн НДХ 1.8 сая/;*
- *Сэлэнгэ аймгийн НДХ 4.2 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй;*
- *Булган аймгийн НДХ 88.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулаагүй.*

2.8.7. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,090,690.7 сая, эцсийн үлдэгдэл 1,529,563.6 сая төгрөг болж, 438,873.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №9. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,209.8	12,209.8	0.0
Өмч /төрийн/	12,209.8	12,209.8	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,074,061.1	1,512,934.6	438,873.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,419.8	4,419.3	-0.5
Дүн	1,090,690.7	1,529,563.7	438,873.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 438,873.0 сая төгрөгөөр нэмэгдсэнд 446,532.3 сая төгрөгийн тайлант үеийн үр дүнгийн өсөлт, бүртгэлийн бодлогын өөрчлөлт буюу давхар ажил эрхэлсний илүү төлсөн шимтгэлийн буцаалт, илүү дутуу олгосон тэтгэвэр тэтгэмжийн залруулгыг өмнөх үеийн үр дүн рүү 7,658.8 сая төгрөгөөр бууруулах бичилт хийсэн нь нөлөөлсөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулиар Нийгмийн даатгалын сангийн 2,208,833.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас шимтгэлийн орлогоос 1,603,341.0 сая, улсын төсвөөс 605,492.8 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр нийт 2,485,005.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 12.5 хувиар давсан байна.

Хүснэгт №11. Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	1,859,929.0	2,071,090.2	211,161.2	83.3
Тэтгэмжийн даатгалын сан	132,949.5	157,542.1	24,592.6	6.3
ҮОМШӨвчний даатгалын сан	172,988.9	214,836.3	41,847.4	8.7
Ажилгүйдлийн даатгалын сан	42,966.4	41,537.1	-1,429.3	1.7
Дүн	2,208,833.8	2,485,005.7	276,171.9	100.0

Тайлант хугацаанд 2,068,539.6 сая төгрөг зарцуулах төсөв баталснаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд 2,043,784.5 сая, даатгалын байгууллагын үйл ажиллагаанд 24,755.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Нийт 2,062,270.0 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл 99.7 хувьтай байна.

Хүснэгт №10. Нийгмийн даатгалын батлагдсан зардал, гүйцэтгэл /сая төгрөг/

Батлагдсан зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	1,859,928.7	1,839,194.9	-20,733.8	89.2
Тэтгэмжийн даатгалын сан	116,178.5	126,220.8	10,042.3	6.1
ҮОМШӨвчний даатгалын сан	55,174.0	52,854.1	-2,319.9	2.6
Ажилгүйдлийн даатгалын сан	37,258.4	44,000.2	6,741.8	2.1
Дүн	2,068,539.6	2,062,270.0	6,269.6	100.0

Тэтгэмжийн даатгалын сангийн зардал батлагдсан төсвөөс 10,042.3 сая, ажилгүйдлийн даатгалын сангийн зардал 6,741.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь уул уурхайн лиценз цуцлагдаж аж ахуйн нэгж байгууллагууд татан буугдсантай холбоотойгоор тэтгэмж өссөн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд зарцуулах баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нэмэлт төсөв: Засгийн газрын нөөц хөрөнгөөс 87.2 сая, нийгмийн даатгалын сангаас төсөв захирагчид 392.9 сая, хандив тусламжаар 220.3 сая буюу нийт 700.4 сая төгрөгийн орлогыг нэмэлт төсвөөр санхүүжигдсэн байна.

Нэмэлт санхүүжилтээс салбарын ажилчдын чадавхыг сайжруулах сургалтад 433.5 сая, тэтгэмж урамшуулал, буцалтгүй тусламжид 96.7 сая, цалинд 125.4 сая, урсгал засвар болон хөрөнгө худалдан авахад 24.6 сая нийт 680.2 сая төгрөг зарцуулсан байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 34 байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайлан, сангийн 31 санхүүгийн тайлан нийт 65 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 3 төсвийн захирагчийг түүвэрт хамруулсан бөгөөд хамрагдсан бүх байгууллагууд “Зөрчилгүй” дүгнэлт авсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 121,961.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 27.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 101,95.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 19,979.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн байна. Үүнээс нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн аудитаар 111,626.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсний 65.0 сая төгрөгийн алдааг залруулж, 100,949.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэн, 10,612.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэснийг залруулав. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 2019 оны эхний үлдэгдлийг 2018 оны аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эцсийн үлдэгдлээс хөрөнгө, эх үүсвэр тус бүр 2.0 сая төгрөгийн зөрүүтэй;
- Санхүүгийн байдлын тайлангийн урьдчилж гарсан зардал дансны эцсийн үлдэгдэл 76 тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийн дүн 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлангийн "төсөл/сан" 34.8 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгөөр тайлагнасан;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан болон тодруулга тайлангийн урсгал шилжүүлгийн зардал 25.3 сая төгрөгийн зөрүүг залрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Монгол банкнаас хянасан зохист харьцааны үзүүлэлт шаардлага хангахгүй, санхүүгийн байдлын тайлангаар алдагдалтай, өөрийн хөрөнгийн хэмжээ болон эрсдэлийн сан сөрөг дүнтэй нэр бүхий 2 банкны харилцах дансанд байршиж байгаа 100,943.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн байна.

Энэ нь Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “Банк дараахь шаардлагыг хангаж ажиллана”, 16.1.1 “заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу зохих хэмжээ, хэлбэрээр хангахын зэрэгцээ хадгаламж эзэмшигч,

харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх”, 16.1.2 “өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу биелүүлэх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 “нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого зарлагын гүйцэтгэлийг хангах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

2. НДС-ийн үнэт цаасны тооллогоорх дүн нягтлан бодогч болон нярвын тайлангаас 27410 ширхэг буюу 5.6 сая төгрөгийн зөрүүтэй байна. Нягтлан бодогч өмнөх сарын бүртгэлтэй, нярав өдөр тутмын бүртгэлтэй ч агуулахын хадгалалт, хяналтын шаардлага хангагдаагүй, үнэт цааснууд нь эмх замбараагүй, дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 “Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.3.2 “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт, Санхүүгийн тайлангийн Оршин байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчид 10,612.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа нийгмийн даатгалын хэлтсүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 10,736.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 336.8 сая төгрөгийн алдааг залруулж, 27.5 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 1,004.6 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага хүргүүлж, 9,367.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 85 зөвлөмж өгсөн байна.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг хадгаламж хэлбэрээр арилжааны банкуудад байршуулах асуудлыг эрсдэлд суурилсан судалгааг үндэслэн шийдвэрлэж байх шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Нийгмийн даатгалын сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 2019 онд 8159 мэдээллийг хугацаанд нь, 1310 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 216 мэдээллийг байршуулаагүй буюу 97.8 хувийн хэрэгжилттэй ажилласан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 105,305.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хууль хяналтын байгууллагатай хамтран үе шаттайгаар арга хэмжээ авч шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС, АОУС, журам, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай дүгнэлт

Залруулагдаагүй 121,961.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 23,989.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлтийг өгч байна.

